



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн
нам (САИНН)-ын дүрэм (шинэчилсэн
найруулга)-ийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Н.Баярмаа, Н.Батчимэг, Н.Батзориг, М.Батсуурь, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Д.Цолмон, Б.Ундрах, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэм (шинэчилсэн найруулга)-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч М.Батсуурийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын үүсгэн байгуулагч Б.Жагараас "... намын дүрэм (шинэчилсэн найруулга)-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх тухай" өргөдлийг 88 хуудас баримт, 1 ширхэг флашны хамт 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан "Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам"-ын дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлж, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг.Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН) нь хуульд нийцүүлэн намын дүрмээ бүртгүүлэхээр өмнө нь Улсын дээд шүүхэд 4 удаа өргөдөл гаргасан бөгөөд процесс болон дүрмийн өөрчлөлттэй холбоотойгоор Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 37 дугаар тогтоолоор 12 үндэслэлээр, 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолоор 6 үндэслэлээр тус тус бүртгэхээс татгалзаж, харин Улсын дээд шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 04/2376 албан бичгээр 18 дугаар тогтоолын зөрчил арилаагүй үндэслэлээр буцааж, мөн дахин дүрмийн өөрчлөлттэй

холбоотойгоор Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор 7 үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн. САИНН нь эдгээр шүүхийн шийдвэрт дурдсан алдаа, зөрчлийг бүрэн арилгасан байна.

Хоёр.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн (цаашид “Хууль” гэх) 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж,

Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын 2023 оны дүрмийн 6.6-д “Намын Их Хурал нь бодлогын үндсэн асуудлыг хэлэлцэн, онцгой бүрэн эрхийн хүрээнд дараах асуудлыг шийдвэрлэнэ.” гээд 6.6.1-д “Намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг хэлэлцэн батлах, өөрчлөлт оруулах” гэж тус тус заасан.

Өргөдөл, түүнд холбогдох баримтуудаас үзвэл, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын Ээлжит бус Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 25/06 дугаар тогтоолоор намын дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг баталсан үйл ажиллагаа нь процессын хувьд зөрчилгүй, харин дүрмийн зарим заалт нь хуульд нийцээгүй байсан тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 61 дүгээр тогтоолоор бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Уг тогтоолд дурдсан зөрчлийг арилгахаар 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын төлөөллийн төв байгууллага болох Бага хурал хуралдаж, 26/03 дугаар тогтоолоор намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, баталсан үйл ажиллагаа нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намын дүрэм болон хуульд нийцжээ. Тодруулбал:

2.1.Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрмийн 7.3.2-т “Намын Бага хурлын хуралдааныг САИН намын дарга, эсхүл намын Бага гишүүдийн гуравны хоёр ба түүнээс дээш гишүүдийн саналаар зарлан хуралдуулж болно” гэж заасны дагуу тус намын даргын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/26/01 дүгээр албан бичгээр Бага хурлыг 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр товлон хуралдуулсан ба 26/01 дүгээр тогтоолоор намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Бага хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэж, хурлын зарыг намын фэйсбүүк хуудсаар гишүүдэд хүргэсэн болох нь холбогдох баримтуудаар тогтоогдсон болно.

2.2.Намын дүрмийн 7.1-д “Намын төлөөллийн төв байгууллага нь САИН намын Бага хурал байна. Намын Их хурал нь намын Бага хурлыг 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Их хурлын нийт төлөөлөгчид нууцаар санал хурааж сонгон дараагийн Их хурал хуралдах хүртэлх хугацаагаар байгуулах бөгөөд Бага хурлын гишүүд улиран сонгогдож болно”, 7.2-т “Намын Бага хурал нь дараах эрх, үүрэгтэй байна.” гээд 7.2.11-д “Намын Их хурлын чөлөөт цагт намын Бага хурлын бүрэлдэхүүнд сул орон гарвал нөхөн сонгох, батлах, Дүрэм ёс зүйн ерөнхий хорооны бүрэлдэхүүнд сул орон гарвал батлах”, 7.3.4-т “Намын Бага хурлын бүх гишүүдийн гуравны хоёр ба түүнээс дээш гишүүд оролцож байгаа үед намын Бага хурлыг хүчинтэйд тооцно” гэж тус тус заасан.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн хурлын ирцийн бүртгэл, фото зураг, дүрс бичлэг болон бусад баримтаар намын 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Бага хуралд

8 гишүүн оролцсон; уг гишүүдийг Бага хурлын гишүүн эсэхийг Улсын дээд шүүхэд хадгалагдаж буй тус намын хувийн хэргээс шалгахад намыг үүсгэн байгуулах Их хурлын төлөөлөгчдийн 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоол, Бага хурлын “Нөхөн томилох тухай” 2023 оны 01, 03, 06, 07, 2024 оны 24/02, 24/06, 24/07 дугаар тогтоолуудаар батлагдсан гишүүд мөн байх тул зөрчилгүй байна.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах ил санал хураалтад 8 гишүүн оролцож, 100 хувь дэмжсэн санал өгсөн болох нь тус 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Бага хурлын тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдож байна.

2.3.Хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж, харин намын дүрмийн 7.2-т “Намын Бага хурал нь дараах эрх, үүрэгтэй байна.” гээд 7.2.16-д “Намын Их хурлын чөлөөт цагт намын дүрэм, мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах асуудлыг Бага хурлын гишүүдийн гуравны хоёроос багагүй гишүүдийн саналаар шийдвэрлэн батлах. (Энэхүү өөрчлөлт нь намын бүтэц, зохион байгуулалттай холбоотой болон намын дотоод ардчилал, эв нэгдэлд сөргөөр нөлөөлсөн гишүүдийн эрх тэгш байдлыг алдагдуулсан, эрхийг хязгаарласан байхыг хориглоно)” гэж тус тус заажээ.

Өмнөх, САИНН-ын Ээлжит бус Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 25/06 тогтоолоор намын дүрэм нь 22 бүлэг, 177 заалт, 329 дэд заалттай байсан, үүний 10.2 хувь болох 13 заалт, 41 дэд заалтад нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, намын дүрмийн 7.2.16-д заасантай нийцэж байна.

Гурав.Дээрх Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 61 дүгээр тогтоолоор дүгнэсэн 7 зөрчлийг Бага хурлын 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 26/03 дугаар тогтоолоор баталсан намын дүрэмд дараах байдлаар засаж ирүүлжээ. Үүнд:

3.1.Тогтоолын 1.1-д “Хуулийн 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн Удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхийн асуудлыг намын дүрмийн 7.2.16-д “Намын Их хурлын чөлөөт цагт намын дүрэм, мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах асуудлыг Бага хурлын гишүүдийн гуравны хоёроос багагүй гишүүдийн саналаар шийдвэрлэн батлах ...” эрхийг Бага хурал хэрэгжүүлэхээр заасан нь хуульд нийцэхгүй” гэснийг “Намын Их хурлын чөлөөт цагт намын дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг Бага хурлын гишүүдийн гуравны хоёроос багагүй гишүүдийн саналаар шийдвэрлэн батлах бөгөөд энэхүү дүрмийн 18.4 дэх заалтыг баримтална ...” гэж;

3.2.Тогтоолын 1.2-т “Намын дүрмийн 7.4.7.6-д “Намын бага хурлын гишүүнийг чөлөөлөх санал хураалтыг энэхүү дүрмийн 7.3.6 дахь заалтын дагуу явуулах бөгөөд бага хурлын гишүүдийн олонх огцруулах саналыг дэмжсэн тохиолдолд огцорсонд тооцно” гэж зохицуулсан нь ойлгомжгүй, хэм хэмжээ хэрэглээний тодорхой бус байдал үүсгэх үр дагавартай байна ...” гэснийг “... Бага хурлын гишүүдийн олонх чөлөөлөх саналыг дэмжсэн тохиолдолд чөлөөлөгдсөнд тооцно” гэж;

Мөн “Намын дүрмийн 13.8-д “Намын хяналтын хорооны гишүүнийг огцруулах, чөлөөлөх”, 13.8.1-д “Энэхүү дүрмийн 3.5, 3.6-д зааснаас бусад тохиолдолд намын

хяналтын хорооны гишүүнийг чөлөөлөхийг хориглоно”, 13.8.2-т “Намын хяналтын хорооны гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ өгөх эрхтэй” талаар дурдсан боловч огцруулах үндэслэлийг нэрлэн заагаагүй байна ...” гэж дурдсан зөрчлийг засаж намын дүрмийн 13.8 дахь заалтыг “Намын хяналтын хорооны гишүүнийг чөлөөлөх” гэж, 13.8.1-13.8.2 дахь заалтуудыг өөрчилж, 13.9-д “Хяналтын хорооны гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна” гэж, 13.8.3, 13.9.1 дэх заалтуудыг нэмж тус тус үндэслэлийг тодорхой зааж;

3.3.Тогтоолын 1.3-т “... Намын шинэчилсэн дүрмийн 3.5-д санаатай зөрчлийг жагсаан тогтоосон боловч “ноцтой зөрчил”-ийн хүрээ хязгаарыг хуульд заасан шалгуураар хэмжихээр нээлттэй үлдээсэн гэж үзэхээр байна ...” гэснийг 3.6-т “Дараах тохиолдлыг ноцтой зөрчилд тооцож Хяналтын хорооны шийдвэрээр гишүүнчлэлээс шууд хасна” гэж нэмж;

3.4.Тогтоолын 1.4-т дурдсан “Намын дүрмийн 9.2.1-д “Удирдах Зөвлөлийг намын Ерөнхий нарийн бичгийн даргыг оролцуулан 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Бага хурлаас сонгоно” гэж намын гүйцэтгэх төв байгууллагын бүрэлдэхүүнийг нууц санал хураалтаар сонгохоор хуульд заасан байхад Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхий нарийн бичгийн даргыг оролцуулахаар зохицуулсан нь хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-д нийцэхгүй гэсэн зөрчлийг “Удирдах Зөвлөлийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Бага хурлаас сонгоно” гэж;

3.5.Тогтоолын 1.5-д “... намын гишүүнээс “түдгэлзэх үндэслэл”-ийг дүрэмд тодорхойлоогүй, эсхүл тодорхойлоход дэм болохуйц объектив шалгуурыг бий болгоогүй гэж үзэхээр байна” гэж дурдсныг намын дүрмийн 3.7-д “Хуульд заасны дагуу төрийн зарим албан тушаалтан, албан хаагчийг намаас дараах журмыг баримтлан түдгэлзүүлнэ” гэж өөрчилж, 3.7.1-3.7.4-т намын гишүүнээс түдгэлзэх үндэслэлийг тодорхойлж;

3.6.Тогтоолын 1.6-д “... Намын дүрмийн 7.2.34-т “Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг дотоод аудиторыг 4 жилийн хугацаатай Бага хурлын гишүүний санал оруулснаар томилно. Дотоод аудиторыг нэг удаа улируулан томилж болно” гэж зохицуулсан боловч дотоод аудиторыг нөхөн томилох талаар дүрэмд тусгах нь зүйтэй” гэснийг “Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг дотоод аудиторыг 4 жилийн хугацаатай Бага хурлын гишүүний санал оруулснаар томилох, нөхөн томилох. Дотоод аудиторыг нэг удаа улируулан томилж болно” гэж;

3.7.Тогтоолын 1.7-д “... намын даргыг “сонгох”, “чөлөөлөх”, “огцруулах” үндэслэл, шийдвэр гаргах журмыг намын дүрмээр тус тусад нь тодорхой заах шаардлагатай.... Намын даргыг чөлөөлөх, огцруулах үндэслэлийг ялган зааглаагүй нь хуулийн дээрх шаардлагад нийцэхгүй байна” гэснийг намын дүрмийн 8.6 дахь заалтад “Намын даргыг сонгох, нөхөн сонгох” гэж, 8.7 дахь заалтыг 8.7-д “Намын даргыг дараах үндэслэлээр чөлөөлнө” гэж тус тус өөрчилж, 8.8-д “Намын даргыг дараах үндэслэлээр огцруулна”, 8.6.2-8.6.4-т заасныг нэмж тус тус өөрчилжээ.

Иймээс, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэм нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан, дээрх тогтоолд дурдсан зөрчлүүдийг залруулсан тул бүртгэх нь зүйтэй гэж үзэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалтыг баримтлан Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ